



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018.04.05 № 20

Асуулга тавих тухай

Улсын Их Хурлын гишүүн миний иргэдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Өргөдлийн байнгын хорооны даргын хувьд иргэдийн болон нийтийн хүлээлт болсон зээлийн хүүгийн асуудлаар Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:


1. Зээлийн хүүг бууруулах асуудлын хүрээнд Засгийн газрын зүгээс болон бусад байгууллагын зүгээс энэ хугацаанд ямар ажлууд хийгдэж ямар үр дүнд хүрээд байгаа талаар;
2. Зээлийн хүү буурахгүй байгаа үндсэн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийг холбогдох байгууллагууд, ажлын хэсгүүдийн зүгээс юу гэж үзсэн болох;
3. Засгийн газар энэ тал дээр ямар байр суурьтай байгаа болон цаашид ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа;
4. Ер нь эдийн засагт хүүгийн түвшинг иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүлээлт болоод буй нэг оронтой тоонд оруулах боломж байгаа эсэх, байгаа бол ямар хугацаанд хэрэгжүүлэх боломжтой;
5. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд орон сууцны зээлийн хүүг 6% хүртэл бууруулах боломж байгаа эсэх, Ипотекийн зээлийг бодитоор явуулах, дахин төлөвлөлтөөр орсон иргэдийг хамруулахын тулд санхүүжилтийг нэмэгдүүлэх ямар арга хэмжээ авч байгаа талаар;

Эдийн засгийн нөхцөл байдал бүрэн сайжраагүй, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд зээлийн хүүгийн дарамтад байгаа энэ нөхцөл байдал нь Засгийн газрын гол анхаарах асуудлын нэг гэж үзэж байна. Түүнчлэн энэ асуудалд Засгийн газрын зүгээс тодорхой байр сууриа илэрхийлэхгүй бол энэ нь зарим нэг хүний улс төрийн тоглолт хийж иргэдийн сэтгэл санааг үймүүлэх, талцуулах арга хэрэгсэл болоод байгаа нь бодит үнэн юм.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэх, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



М.ОЮУНЧИМЭГ

0000000015